


### МОНГОЛЫН ХОШУУ НУТГИЙН ЗУРГИЙН ЗУРАГ ЗҮЙН ХУВЬСАЛ БА ЧИН УЛСЫН МОНГОЛ ЗАХИРГАА

КАМИМУРА Акира

#### Оршил -Хэлбэргүй газар ба хэлбэртэй газар

Зураг 1-д харуулсан газрын зураг нь 1805 он (Сайшаалт ерөөлтийн 10-р он)-д гарсан тухайн үеийн Чин улсын засаг захиргааны нэгж байсан нэгэн хошууны газрын зураг юм. Дөрвөлжин цаасны ихэнх хэсгийг дүүргэн хошууны газар нутгийг зурсан боловч зэргэлдээх хошуутай хиллэх хил заагийг тэмдэглэсэн зураас алга. Гэтэл зуу гаран жилийн дараа мөн



хошууг зурж тэмдэглэсэн Зураг 2 дээрх газрын зурагт хошууны хил заагийг хилийн тэмдэглээ (овоо)-ний дагуу улаан шугамаар тэмдэглэсэн байх тул, хошууны гадаад байдал, өөрөөр хэлбэл “хэлбэр” нь тодорхой мэдэгдэж байна.


**Зураг 1.** Халхын Сэцэн хан аймгийн тэргүүн зэрэг тайж Гомбожавын хошуу (Халхын дорно замын дундад адгийн баруун этгээдийн хошуу)-ны нутгийн зураг (1805 он). Токиогийн Гадаад Судлалын Их Сургуулийн номын сан.

Камимүра Акира

Токиогийн Гадаад Судлалын Их Сургууль  
kamimura.akira@tufs.ac.jp

Фүтаки Хироши, Камимүра Акира, Э.Равдан, Л.Чулуунбаатар

Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд  
МУИС пресс хэвлэлийн газар, Улаанбаатар, 2012, ISBN 978-99962-72-59-2



**Зураг 2.** Мөн хошууны нутгийн зураг (Сэцэн хан аймгийн засгийн тэргүүн зэрэг тайж хоёр зэрэг тэмдэглэсэн Лувсанчойдов-Агванпилжээ-Дашцэрэнгийн хошууны нутгийн зураг, 1907 он). ХБНГУ-ын Берлиний мужийн номын сан. ([http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III-Hs\\_or\\_0012](http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III-Hs_or_0012))

Өнөө үед, газар гэхээр хил зааг нь тодорхой, тогтсон “хэлбэр” бүхий зүйл бидний санаанд буух нь олонтоо. Жишээ нь улс, муж, хот, аймаг гэх мэт засаг захиргааны нэгжийн газар нутаг, улмаар жижигрэн хувь хүний эзэмшлийн газар гээд бүгд л хэлбэр бүхий зүйл болон бууж байдаг.

Гэхдээ тэрхүү “хэлбэр” тогтохын урьтал нь газрыг эзэмшин ашиглах тогтолцоо болон хэмжих аргачлалын хөгжил гэсэн тодорхой нөхцөл байдаг. Өөрөөр хэлбэл, тогтсон хэн нэгэн /тэр нь улс байх үе ч бий/ тогтсон хэсэг газрыг захирсан хамааралд байхын зэрэгцээ, газрын “хэлбэр”-ийг зөв хэмжин тогтоож, түүнийг газрын зурагт буулгах аргачлал ч шаардлагатай гэсэн үг. Аргачлал нь нийгэм эдийн засгийн тогтолцооны байдал болон захиран суух арга замын эх үүсвэр болдогтой холбогдоно. Тухайлбал, энд авч үзсэн газрын зураг нь Чин улсын засгийн газраас монголын орон нутгийн захирагчдад тушаан, гаргуулж авсан зураг бөгөөд дээрх хоёр зургийг зурсан байдлын ялгаа бол тухайн газар болон тэнд аж төрөх хүмүүс рүү чиглэсэн захирагч ангийн хандлагын ялгаа, засаглах аргын ялгаа гэж хэлж болно.

Тэдгээр газрын зургийг зурсан байдлаас ажиглагдах засаглах аргын ялгаа гэж чухам юу юм бол? Улмаар, тиймэрхүү ялгаа гарах болсон цаад шалтгаан нь юу байв гэдгийг Чин улсын үеийн монголын хошуудын газрын зураг болон түүнд холбогдох сурвалжаар дамжуулан энэхүү өгүүлэлдээ тодруулахыг зорьлоо.

## 1. Газрын зураг ба эрх мэдэл

Б. Андерсон (2007) нь улс орны тусгаар тогтнох эрхийг олгодог газар нутгийн “хэлбэр” нь ард түмний төсөөлөх чадвартай гүн гүнзгий холбоотой байдгийг “Газрын зургийн лого” гэсэн үгээр судалгаандаа дурдсан байдаг бөгөөд эзэнт гүрэн өөрийн захирах колони орныг газрын зураг дээр өнгө ялган зурдаг болсноос, эвлүүлдэг зургийн нэг хэсэг шиг хэлбэр нь дэвсгэр зурагнаас сугарч гаран тухайн колони орны бэлэгдэл болж, улмаар тэр колони орны үндэсний үзлийг ард түмэнд ойлгуулах чухал арга замын нэг болсон гэж тэмдэглэсэн байдаг. Мөн Т. Виничакул (2003) Тайландын газар нутаг болон ард түмний холбоо хамаарлын тухайд “Газарзүйн бие (Geo-Body)” гэсэн ойлголтыг гарган тавьж, хилийн шугам бүхий тогтсон зураглалтай газар нутгийнх нь зураг л Тайланд үндэстнийг бий болгосон юм хэмээн онцолсон байдаг.

Социалист орон байсан Монгол орны үндэсний үзэлд ч эдгээр судалгааны загварууд холбоотой. Хотоор жаахан алхвал газар нутгийнх нь хэлбэр лого маягаар ашиглагддаг жишээг харж болно. Түүнчлэн Монгол орны “газарзүйн бие” нь 1939 оны Халх голын дайны үеэр бүрэлдэн тогтносон бөгөөд дайны дараа монголчуудын төсөөлөлд гүнзгий нэвтэрсэн билээ. Өөрөөр хэлбэл, 1930 оноос японы цэрэг (Квантуны арми) хил зөрчих нь олширсон болон түүнээс үүдсэн Халх голын дайн нь, хил бол улс орны тусгаар тогтнолын орон зайн хязгаар юм гэдгийг ард түмэнд тодорхой ойлгуулсан явдал болсон гэсэн үг. Энэ дайнаас л, эх болон илэрхийлэгдсэн “Эх орон” болон “Халдашгүй дархан хил” хэмээх ойлголт бий болсон (Kamimura 2010).

Газрын зурган лого нь олны дунд нэвтэрч ард түмэн бүрэлдэн бий болохын тулд адил мэдээллийг олон хүнд дамжуулах тогтолцоо шаардлагатай байдаг. Монголын хувьд 1937 онд орос эрдэмтэн А. Д. Симуковын бүтээсэн “Ногоон зураг” хэмээх монгол орны газрын зураг 300 хувь хэвлэгдсэнээр улс орны газрын зураг нийтэд өргөн тархах болсон байна. Б. Андерсоны дурдсан мэт “хэвлэлийн капитализм” монголд хөгжөөгүй байсан хэдий ч, хуулбарлан буулгах хэвлэлийн аргын ачаар, улс орны засаг захиргаа, боловсрол, цэрэг татлагын тогтолцоо бүрэлдэн тогтохтой зэрэгцэн, газар нутгийн хэлбэр хүмүүсийн төсөөлөлд гүнзгий шингэсэн билээ.

Б. Андерсон хүн амын судалгаа болон музейтэй хамт дурдсанчлан, орчин цагийн газрын зураг нь засаглалын төлөөх хэрэгсэл болж колончлолын үеэс өнөө хүртэл уламжлагдан ирсэн юм. Газрын зураг нь эзэнт улсын захирагч болон нутгийн сурвалжит хүмүүсийн гараас, хуулбарлан буулгах хэвлэлийн аргаар дамжин (хэдий мэдээлэх дургүй хэсгийг арилгасан байлаа ч) өргөн олонд хүрэх болжээ. Үүнтэй зэрэгцэн, газрын зурган дээр дүрслэгдсэн газар нутаг болон ард түмэн рүү хандсан “харц” нь засаглагчид төдийгүй, харагдаж байгаа энгийн иргэдийн сэтгэлд ч агуулагдах болдог аж.

Б. Андерсон (2007) болон Т. Виничакул (2003)-ын судалгаа нь “үндэстэн-улс” (nation-state) бүрэлдэн бий болох явцын талаарх судалгаа бөгөөд ийнхүү цаашид өгүүлэхчлэн, газрын зураг бүтээх шинэ арга маяг нь засаглах арга зам болон монголын төрийг барьсан хүмүүсийн сэтгэлгээнд хэрхэн нөлөөлсөнийг монголын хуучин газрын зургаас ажиглаж болно.

## 2. Хэлэлцээрийн процесс болсон газрын зураг

Хүний үйл ажиллагааны дийлэнх нь газар дээр явагдаж, тухайн газрын онцлог тал дээр нь нөхцөл тавигдахын зэрэгцээ, тэдгээр онцлогийг нь ашиглан, газар нутгийн байдлыг өөрчлөөд явдаг. Газрын зураг нь тийнхүү хүн болон байгалийн хэлэлцээр (negotiation)-ийн процесс болсон газар нутгийн байдлыг буулгаж, хүмүүс түүнийг хэрхэн үзэж, хандаж ирсэнийг илэрхийлж байдаг. Монголд эрхлэх гол аж ахуй нь нүүдлийн мал аж ахуй байсан учраас, газар луу шунах нь бага байсан гэх нийтлэг санаа бодол байдаг нь анзаарагддаг ч, эсрэгээр нүүдлийн мал аж ахуй нь өргөн уудам газар нутгийн бүхий л онцлогийг ашиглаж ирсэн, газар нутгийн байдлын талаарх ойлголт нь нүүдлийн мал аж ахуйн газар ашиглалттай нягт холбоотой байдаг. Туан (1993) судалгаандаа, нүүдэлчид “газрын талаарх мэдрэмж маш сайтай” (х.322) хэмээн дурдсан байдаг. Түүнчлэн Вакабаяши (2009) түүнээс ишлэл аван,



нүүдэлчдийн орон зайн өндөр мэдрэмж, чадвар болон тэдний газрын зураг бүтээх хэрэгцээ шаардлагын талаар дурдсан байна (х.74-77). Үнэндээ ч монголын нүүдэлчин ардад эртнээс газрын зураг бүтээх аргачлал байгаагүй гэж хэлэхийн аргагүй. Жишээ нь, Монголын эзэнт гүрний үед дэлхийн газрын зураг бүтээгдсэн байдаг. Мөн, 18-р зуунд баруун монголд өнөөгийн түвшнээс харсан ч хангалттай сайн үнэлгээ авах газрын зураг ашиглагдаж байсан нь мэдэгдээд байна<sup>1</sup>.

Энд өгүүлэх монголын хуучны газрын зураг нь Манжийн захиргааны үе болох 18-р зуунаас тусгаар тогтнолын дараах 1920-д он хүртэл бүтээгдсэн, уртраг өргөрөг болон тэгш өндрийн шугам байхгүй гараар зурсан зургууд болно. Өдгөө монголд үлдсэн хуучны газрын зургуудад өртөө, харуулын байршлын зургууд ч ордог бөгөөд тэдний ихэнх нь манжийн үед бий болсон засаг захиргааны нэгж болох хошууны нутаг дэвсгэрийн зургууд байдаг. Хятад цаас болон даавуун дээр бэх болон зургийн хэрэгслээр уул толгод, гол мөрөн, нуур булаг, ой мод, говь цөл гэх мэт байгалийн үзэмж байдал, дээр нь худаг, зам, даваа гүвээ, овоо, тариалангийн газар, сүм хийдийн барилгууд, тамгын газар гэх мэт зүйл зурагдсан байх агаад тус тусын оноосон нэр, тайлбараас гадна газрын зургийн нэр, он сар, тайлбар тэмдэглээ, зүг чигийг монгол бичиг болон манж бичгээр, эсвэл хятад үсгээр бичсэн байдаг.

Хошууны нутаг дэвсгэрийн зураг нь, манжийн хаад хошуу ноёдоор дамжуулан тухайн нутаг дэвсгэр болон иргэдийг нь захирахын бэлгэдэл, мөн арга зам нь байжээ. Нөгөө талаар монголын газрын зургуудыг зурах арга барил өөрчлөгдөн солигдож ирсэн нь, нүүдэлчин малчид, сурвалжит язгууртнууд болох хошуу ноёд болон хуанди төвтэй эрх баригчдын засаглах аргыг тойрсон хэлэлцээрийн явцыг зааж байдаг гэж хэлж болно.

17-р зууны сүүл үеэс аваад өнөөгийн Монгол улсын нутаг дэвсгэрт аж төрж буй хүмүүс бол манжийн дарлалд орж, хошууны тогтолцоо гэсэн засаг захиргаа нь цэрг-захиргааны бүтцэд шилжсэн бөгөөд монголын ноёд язгууртнууд өөрсдийн нутаг дэвсгэр, ард иргэд нь харьяалагдах болсон хошууг захирах засаг хэмээгдэн угсаа залгамжлан суух болжээ. Тэгэхдээ хошууны газар нутаг нь ноёд язгууртнуудаас хуандид нэг удаа өргөх зүйл бөгөөд хошууны газрын зургийг Чин улсад өргөн барьдаг байжээ. Тэгээд, Манжийн хаанаас эргүүлэн хошууны нутаг нь “шан харамжийн газар” болон ирж, тэдгээр ноёд ч Гадаад монголын төрийг засах явдлын яамаар дамжуулан, хошуу ноён болгон томилсон хуандийн тамгыг даруулан авдаг. Гэхдээ энэ нь хошууны нутаг, хошуу засаг болон хуандийн харилцааг бэлгэдэн илэрхийлсэн бүдүүвч зураг төдий зүйл бөгөөд үнэндээ Тэнгэрийн тэтгэсэн хааны үеэс хошууны газар нутгийн хилийг тогтоон, газрын зурагт буулгасан гэж сурвалж бичигт тэмдэглэгдсэн байдаг ч тухайн үеийн газрын зураг бараг үлдэж хоцорсонгүй.

### 3. Дайчин улсын хураангуй хууль бичгийн зурагт орсон газрын зураг

Харьцангуй олон газрын зураг үлдэж хоцорсон анхны үе бол Зураг 1 дээрх газрын зураг зохиогдсон 1805 он (Сайшаалт ерөөлтийн 10-р он) юм. Энэ үед Чин улсын хууль цааз, улс төрийн тогтолцооны талаарх түүвэр болох “Дайчин улсын хураангуй хууль бичиг” (大清會典) эмхэтгэх ажил өрнөж, түүний хавсралт болох “Зарлигаар тогтоосон Дайчин улсын хураангуй хууль бичгийн зураг” (欽定大清會典輿圖)-д оруулахын тулд засаг захиргааны нэгж бүрийн газрын зургийг Чин улсын захиргаанд байсан газар бүрт хийлгүүлсэн байна.

Сайшаалт ерөөлтийн 10 дугаар он буюу 1805 оны дөрөвдүгээр сарын шинийн гурваны Сэцэн хан аймгийн “да гүн Го /Гомбожав/, дэд да хэбэй бэйс Го /Гончигжав/ нарын Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин хэбэй амбас (Улиастайн жанжин)”-д өргөсөн бичигт (МУТА:М31-2-172-5):

“Olan muji-yin kereg-i sidgekü quriyangyui qauli bičig jokiyaŋu üiledkü ŋaŋarun ergügsen inu, man-u jūŋan-ača jarliŋ-i daŋaŋu qauli bičig jokiyaqu üiledküi-dür

<sup>1</sup> Ренато (Renat) хэмээх швед хүн баруун монголын Зүүнгарын хаант улсаас авч очсон зураг (Baddeley 1919).

egiin-ü dotora, ʎaʎar oron-i ʎiruʎ nigen jüil-dür aliba olan ʎadayadu ayimaʎ-un ayula ködege kiʎaʎar ʎaʎar-i cöm erke ügei naribcılan todorqayılan bayičaʎaʎu ʎiruʎ ʎiruʎu niʎtalaʎulaysan qoyin-a, debsigülüged, deger-e tolidqu-dur beledgegülimii.”

гэж “Олон мужийн хэргийг шийтгэх Хураангуй хууль бичиг зохиож үйлдэх газар” (會典館)-ын өргөснөөс иш татжээ.

Үүнээс үзвэл, ”Хураангуй хууль бичиг” эмхэтгэн гаргахад ”Гадаад аймаг” (外藩)-ын газар усны нэрийг сайтар нягтлан шалгаж, газрын зураг хамт хийхээр тогтсон бололтой.

Мөн дээрх газрын зургийн (Зураг 1) хошууны “Хардэл засаг Гомбожавын тамгын туслагч, түшмэдийн бичиг” буюу “Хэрлэн барс хотын чуулганы дарга засгийн улсад туслагч гүн, чуулганы дэд дарга хэбэй засгийн хошууны бэйс”-д Сайшаалт ерөөлтийн 10-р он (1805) тавдугаар сарын арван хоёрны өдөр газрын зураг, цэстэйгээ хамт өргөсөн бичигт (МУТА: M31-2-172-3):

“ayimaʎ-un olan ʎasaʎ nar, urida olan qosiyun-u nutuʎlaqu ʎaʎar-i qubiyaysan cāʎ-tur, bayiyuluʎsan oboʎ-a-u [sic] ner-e, ʎiçi öber öber-ün nutuʎlaysan ʎaʎar oron-u ner-e, basakü öber öber-ün nutuʎ-un dörben eteged, naiman jüg-tür, ali ayimaʎ cīyulʎan-u ʎasaʎ qosiyud-luʎ-a ʎiq-a neyilegsen ʎaʎar-i erke ügei, uʎ tusiyaysan yosoʎar jüil darayalan todorqayılan bayičaʎaʎu, ʎaʎar usun-u bayidal tölөb-ün yosoʎar ʎiruʎ ʎiruʎu cEsE daʎayulun, ene qaburun dumdadu sarayin arban tabun-u dotor-a erkebisi qurdulan biden-ü ʎaʎar-tur batulan küргеjü ieregüliу-e ...”


хэмээсэн чуулганы дарга нарын газраас ирсэн бичгээс иш татжээ.

Анхны монгол хуучны газрын зургийн онцлог дараах гурван зүйл болно. Нэгд, Зураг 1 дээрх газрын зургийн талаар дурдсанчлан, цаасны нийт талбайг ашиглан хошууны газар нутгийн үзэмж байдлыг зурсан явдал. Энэ онцлог нь, тэр үеийг хүртэлх газрын зураг зурах аргад үндэслэгдсэн хэдий ч “Дөрвөн этгээд, найман зүг”-ийн хил хязгаарыг тодорхой зааж, “газар усны байдал төлвийн ёсоор зураг зурах” гэсэн зарлигийг шударгаар дагасанд оршино. Хоёрт, голыг уран зургийн өнгө аястай зурсан байдал, гуравдугаарт, уулыг хошууны нутаг дэвсгэрийн дотроос, ялангуяа сүм хийд болон хошуу тамгын газрын байрлах газрыг төв болгон гадагш харсан байдлаар зурсан явдал юм. Гэхдээ уул (ялангуяа тахилгатай уул)-ыг хятад болон европын эртний газрын зургууд шиг гурвалжин хэлбэрээр тэмдэглэлгүй, тус тусын өнгө болон хэлбэрийг бодитоор болон хэтрүүллийн аргаар дүрслэн зурсан явдал болон (доорх Зураг 3) уулнаас бусад дурсгалт газар болох сүм хийдийн барилга гэх мэтийг ч томоор бодитоор дүрслэсэн нь он жил улирсан ч үндсэндээ өөрчлөгдөөгүй байна.

Ийнхүү Хураангуй хууль бичигт зориулан газрын зураг бүтээлгэснээр, хошууны хил нь газрын зураг гэхээсээ илүү газрын зураг дээрх үсгэн мэдээлэл гэдгээрээ илүү дэлгэрэнгүй тодорхойлогддог. Гэвч “олон засаг нар, урьд олон хошууны нутаглах газрыг хуваасан цагт” гэж гарч байгаачлан, хошууны хилийг хошууд хоорондоо хэлэлцэн тогтоож байсан нь нэрэн дээрээ хуандийгаас шан болгон өгсөн газар гэж байгаа ч Чин улсад газрын талаар үнэн нарийн мэдээлэл байхгүй, тухайн газарт өөртөө засах илүү газар байсныг харуулж байна.

#### 4. Оросын урагшаа чиглэсэн бодлого ба бодитоор хэмжин гаргасан газрын зураг

Монголын газрын зураг хийх аргачлалд хамгийн том өөрчлөлт авчирсан зүйл бол Бүрэнт засагчийн 3-р он (1864)-ы “Олон улсын хэргийг ерөнхийлөн шийтгэх яам”-ны (総理各国事務衙門) зарлиг юм. Энэ яам нь гадаад харилцааг хариуцах салбар болж 1860 оны Бээжингийн хэлэлцээрийн дараа, Түгээмэл элбэгтийн 11-р он (1861)-нд байгуулагджээ. Орос улс энэ хэлэлцээрээс хойш өнөөгийн монголын нутаг руу хандах нөлөөллөө нэмэгдүүлж, түүний дараах Тарвагатайн хэлэлцээр (1864), Ховд болон Улиастайн хилийн хэлэлцээр (1869) гэх мэт ашиг бүхий улсын хилийн хэлэлцээрүүдийг Чин улстай байгуулжээ. Оросын урагшаа чиглэсэн энэхүү бодлогыг эсэргүүцэхэд нь Чин улсад монгол орны талаарх үнэн зөв гаргасан газрын зургийн шаардлага, өөрөөр хэлбэл, монголыг захирах нөлөөллөө хүчтэй болгох шаардлага бий болжээ.



**Зураг 3** (зүүн) Халхын Сэцэн хан аймгийн арван таван зэрэг нэмсэн, арван найман зэрэг тэмдэглэсэн үе улирах чин вангийн зэрэгт Хурц засаг хошууны бэйс Түдэнгийн хошууны нутгийн зураг (Халхын дорно замын баруун гарын умарт хошуу, 1921 он), Токиогийн Гадаад Судлалын Их Сургуулийн номын сан. (баруун дээд) Улаанаар хүрээлсэн хэсэг. Голын конус хэлбэртэй Зотол уул нь хошууны шүтээн болсон уул. (баруун доод) Зотол уулын зураг (2010 он зохиогчийн авсан зураг)

Бүрэнт Засагчийн 3-р он (1864)-ы 2-р сарын 21-ний Түшээт хан аймгийн “хамаарсан да хэбэй түшээ гүнгийн бичиг” (МУТА:М9-3-4883-2)-т:

“Sečen qan, Ĵasaytu qan, Sayin noyan ayımay-un da nar tan-dur ergün ilegebe. yabuyulqu ucir mönöken Küriyen-ü sayid-ud tan-u ѳajarača tusıyağsan bičig-un dotor-a, olan ulus-un kereg-i yeröngkeyilen sidgekü yamun-ača dalai, jiči qayaly-a-yin jaqayuri muji-dur tusıyağı ѳajarun jıruy-i jıruyulqu jüil-i ayiladqaysan-dur jarliy kelelčegsen yosoğar bolğaytun kemegsen-i kičiyenggüilen dağajı kürger-e iregsen uy kereg-i seyirüljü, öber öberün olan qariyatu ѳajar-tur čingyalan tusıyağı teden-ü Ĵasay tüsımed, ĳadağadu ulus-luy-a ĳalğaldun jıq-a neyilegsen ѳajar oron, basakü dotoğadu ĳadağadu čıyulğan-u olan ĳasay qosıyü, jıq-a qarayul, olan örtege-luy-a [sic] jıq-a neyilegsen ѳajar-un bui бүкүи ağula ĳool-i bey-e tulğı bayıčayan üjejü öber öberün qosıyü, olan qarayul örtege, Ĵibzendamba qutaytu-yin qariyatu süim-e, Küriy-e Kiyaytu qoyar ѳajarun qudaldığan-u irged-iin sayuy-a ѳajar-a, tariyalang küriyeleng, ağulan-u ürgülji tasarqai, yeke bağa öndör boğoni, ĳool ĳoriqan-u eki urusqal adağ salay-a salburi, sarayul tal-a, ĳobi ѳajarun bayidal tölöp ĳam pai kedün-ü ѳajar, ali ѳajar-ača egüskü ali ѳajar-tur kürkü ĳerge yabudal-i tus tus mayadlan kemjıyeljü, ağulan-u qandaqu čig jüg ĳam-un ĳerge ѳajar-i qoyar imaqu-yin dörbeljin kemjıy-e jıruju, basakü ilğan salğajı narin čEsE üiledcü nutuy-un tüsımed, jiči čıyulğan-u daruy-a, řangğudba qrayul-ud-ača küsen batulaqu bičig-üd ĳarğajı ene on ĳurban sarayin dотора biden-ü ѳajar-a medegülün iregülüged, kinan bayıčayajı ulamğilan medegülün yabuyulqui-dur beledgegülsügei. qayucın jıruy-i mördön tasiyarču busud-un nutuy-i qudqan jıruju sayatayulqu ba, nam güim sidgen kümün-ü sedgil-i keredkilgen oros nar-tur ĳadarayulbasu bolqu ügei kemen tusıyan kürcü iregsen tuqai-dur ...”

хэмээн иш татсан “Олон улсын хэргийг ерөнхийлөн шийтгэх яам”-ны зарлигийн дотор, нэг хэсэгт 2 ямх (1 ямх (寸)  $\doteq$  3.2 cm) хирийн график шугам татан, 50 газар (1 газар (里)  $\doteq$  576 m) нь тэрхүү шугамын нэг нүдэнд багтахгаар газрын зураг зурж, мөн цэст түшмэд дарга болон цэргийн тоо, хятад иргэд суурьшсан газрын талаар ч тэмдэглэн оруулахыг шаарджээ<sup>2</sup>. Түүнчлэн өмнөх газрын зурагт дулдуйдан газрын зураг хийж болохгүйг,

<sup>2</sup> Б. Андерсоны (2007) бичсэнчлэн, Монголд ч газрын зураг бүтээх ажил болон хүн амын тооллого холбоотой явагдаж, цэст тайж, лам хувраг, эр эм хүний тоо, сүм хийдийн нутаг дэвсгэр гэх мэт статистикийн тоон мэдээлэл ч оржээ.

орос хүмүүст мэдэгдэлгүй нууцаар хийх тухай заавар ч байжээ. Энэ бичигт, чухам ямар хэмжүүрээр газрын зураг зохиох тухай зөвлөлдөж байгаа талаар дурдаад, бусад гурван аймагт ч мөн хандаж газрын зураг хийх ажилд хамтран ажиллахыг шаардсан байна.

Энд гарч буй чухал зүйл нь нэгд, анх удаа бодит хэмжүүр буюу хэмжилт шаардсан явдал. Мөн хилийн цэс зэргээс үзвэл, хэмжилтэнд нь соронз болон зүг үзэх толь (jüg üjekü toli)<sup>3</sup> ашигласан болохыг мэдэж болно. Үүгээр зүг чигийг хэмжин, зайг тогтооход олс ашигладаг байжээ (Гончигдорж 1970). Хилийн цэст хошууны хилийн тэмдэглэгээ болох овоо хоорондын зай, чиглэл тэмдэглэгдэж, газрын зурагт хошууны хил нь овоог хооронд нь холбосон улаан шугамаар дүрсэлжээ. Хоёрт, 2 ямх (6.4 см)-г харьцах нь 50 газар (28,800 m) буюу 450,000:1 гэсэн масштаб тогтоосон явдал юм. Гэхдээ уртраг өргөрөг ашиглалгүй, хятадын уламжлалт график шугам “計里画方”-ыг ашиглажээ. Гуравт, гол мөрөн нь эгц дээрээс харсан байдлаар зурагдсан байх ба уулын оргилийг нь урагшаа харуулсан байдлаар буюу араас нь харсан байдлаар зурсан явдал юм. Тиймээс газрын зургийн дээд тал нь өмнө зүг болно (Зураг 5).

Дээд хэсгийг өмнө зүг гэж газрын зурагт буулгах нь монголын “уламжлал” гэж шууд үзэж болохгүй ч, монголын нүүдэлчин малчдын “биеийн аргачлал” (techniques of the body)-тай таарна гэж хэлж болно. Гэрийн хаалгыг урагшаа харуулан барьдаг. Гэрийн эзэн хоймортоо урагш харан сууна<sup>4</sup>. Ерөнхийдөө газрын зураг нь хэвтээгээр тавьсан тохиолдолд, доод хэсэг нь үзэгч хүний талд ирэх учир, “өмнө” зүг нь газрын зургийн дээр ирэх нь мэдээжийн хэрэг болно. Ямартаа ч хятадад эрх дархтай хүн урагшаа харж босдог заншил байдаг (Туан 1993:78) ч газрын зургийн дээд талд хойд зүг ирэх нь олон байдаг (Үнно 2004; Ян 1995). Газрын зургийн дээд талыг өмнө зүг гэж үзэх нь дээр дурдсан 18-р зууны баруун монголын газрын зурагт ч мөн адил байх бөгөөд лалынханы газрын зургийн нөлөө байж магадгүй ч, газрын зураг зохиох тал дээр хятадын стандартыг тэр чигээрээ нь ашиглаагүй гэдгийг харуулж байна.

Өмнө зүг гол зүг чиг болдог нь хилийн тэмдэглэгээ болох овооны дугаарт ч тусгалаа олжээ. Хошууны газрын зураг болон хилийн цэст, арван хоёр жилийн морь зүг буюу өмнө зүгт байрлах овоог эхлэл болгон баруун тийш тойруулан дугаарлажээ. Энэ нь газрын зургийн дээд хэсэгт хойд зүгийг тэмдэглэдэг болсон ч өөрчлөгдөөгүй зүйл билээ. Баруунаас эргүүлэхийг “нар зөв тойрох” хэмээн монгол хэлэнд илэрхийлдэг. Янз бүрийн баяр ёслол дахь эргэх үйлдэл нь бүгд баруунаас эргэдэг бөгөөд зүүнээс эргэхийг муу гэж үздэг. Энэхүү баруун эргэх үйлдэл нь бурханы шашны “баруун эргүүлэг” (右繞) гэх ойлголттой ч холбоотой бөгөөд монгол хүний бие махбодын аргачлалтай илүү нийцэх юм.

Хошууны газар нутгийн байдал газрын зураг дээр тодорхой тэмдэглэгдэх болсноор хил хязгаарын будлиантай байдал ч үгүй болжээ. Хошууны газрын зургийг холбон, аймгийн газрын зургийг ч бүтээв. Энэ явцад зөвхөн хошууд төдийгүй, өртөө, харуулын хил хүрээ ч эмх цэгцтэй, давхардалтгүй болжээ. Ийнхүү Чин улс Оростой хийх хэлэлцээрийн явцад өөрийн эрх мэдлийг бататгах хэрэгсэл болох Монгол улсын нарийн тодорхой газрын зургийг гартаа оруулаад зогсохгүй, монгол нутгийг Чин улсын газар нутгийн хүрээнд шууд оруулах үндэс сууриа тавьсан юм.

## **5. Дайчин улсын хураангуй хууль бичгийн зураг ба газрын зургийг дахин нягталсан нь**

Монгол дахь газрын зургийн байдлыг нягтлах сүүлчийн зураг нь Бадаргуулт төрийн 16-р он (1890)-д бүтээгдсэн газрын зураг юм. Ян (1995)-ы судалгаанаас үзвэл, Бадаргуулт төрийн 12-р он (1886)-д “Дайчин улсын хураангуй хууль бичиг”-ийг нэмж засварлан

<sup>3</sup> Жишээ нь Бүрэнт засагчийн 7 дугаар оны (1868) Түшээт хан аймгийн Чимэддоржийн хошуу (Халхын хойт замын дундад зүүн этгээдийн хошуу)-ны цэст “jüg čig-i jüg üjekü tolin-u jüg čig-tür neyilegülin toyтаган abču” гэж байна. (M9-3-5289-17; Зураг 5-2)

<sup>4</sup> Баруун монголд нар мандах зүүн зүг рүү хандуулан гэрээ барьж, тэр зүгийг урд хэмээдэг.



гаргах “Хууль бичгийн газар” (會典館) дахин байгуулагдан, 15-р он (1889)-д “Нэг жилийн дотор муж, сум, хорооны (省,府,縣) зургийг хийж, зурган тайлбартайгаар Хууль бичгийн газарт ирүүлэх” мэдэгдэл гарсан байна<sup>5</sup>. Мөн 17-р он (1891)-д гарсан хоёр дахь мэдэгдэлд “Зарлигаар тогтоосон Дайчин улсын хураангуй хууль бичгийн зураг” (欽定大清會典輿圖)-тай холбогдуулан газрын зураг хийх аргачлалыг дараах байдлаар тогтоосон байна. (1) Газрын зургийн дээд талыг хойд зүг, доод талыг өмнө зүг, зүүн талыг баруун зүг, баруун талыг зүүн зүг гэж үзэх, (2) хятадын уламжлалт график шугамын “計里画方”-ыг ашиглан, нэг нүдэнд, муж (省) бол 100 газар (里)-тай тэнцэх хэмжээг, сум (府) болон нийслэлийн харьяа бүс (直隸州) бол 50 газартай тэнцэх хэмжээг, “тинг” 庁 болон “шиан” 縣 бол 10 газартай тэнцэх хэмжээг тус тус багтааж, газрын зураг дээрх нэг нүдний урт нь нэг ямх (寸)-ын зууны далан хоёртой тэнцэх (七分二厘 23.04 mm) масштаб тогтоох, (3) тогтсон зурган тэмдэглэгээ тогтоох (Зураг 7), (4) тайлбар (газрын зургийн тайлбар бичээс)-ийн зүйлийг жигдлэх, (5) муж (省)-ийн хувьд уртраг өргөрөгийн хэмжилт болон газрын гадаргын хэмжилтийг, боломжтой бол коник тусгалын аргаар хийхийг шаардсан байна (Ян 1995:88). Гэхдээ эхний мэдэгдэлд бараг ижил заавар байсан агаад бүх хошуунаас аймагт Бадаргуулт төрийн 16-17 он (1890-1891)-д өргөн барьсан ихэнх газрын зураг нь бүгд дээд талдаа хойд зүгийг тэмдэглэсэн байдаг. Түүнчлэн, хошуу нь засаг захиргааны нэгжийнхээ хувьд муж (省)-тай адил тул, 100 газрыг нэг нүдэнд багтаах газрын зураг бүтээхийг шаардсан ч, нэртэй том уул, гол мөрөн ч багтахгүй болно гэсэн монголын талын саналын дагуу өнөөг хүртэлх 2 ямхыг харьцах нь 50 газар гэсэн масштабаар хятадын уламжлалт график шугам (計里画方)-ыг ашиглан хийжээ (МУТА:М31-2-3864-1). Бадаргуулт төрийн 15-р он (1889)-д монголд илгээсэн мэдэгдэлд, Энх-Амгалан хааны үеэс хэрэглэж эхэлсэн гурвалжин хэмжилт болон уртраг өргөрөгт тулгуурлан хийгдсэн зураглал “Daqing Yitong Yutu” (大清一統輿圖) (Бүрэнт засагч 2-р он (1863))-с суралц хэмээн бичсэн байх боловч монголчуудын хийсэн хошууны газрын зурагт гурвалжин хэмжилт болон уртраг өргөрөгийг ашиглаагүй байна.

Ийнхүү тогтсон газрын зураг хийх аргачлал нь түүний дараа ч уламжлагджээ. Бадаргуулт төрийн 33-р он(1907)-ы 5-р сарын 29-ний өдөр Сэцэн хан аймгийн чуулган даргаас нийслэлд суух амбан сайдад өргөсөн бичигт (Qariyatu ayimaγ-un bükü nutuγ-un jiruγ, čEsE üiledcü olan qosiyun-u jiruγ-ud-un qamtubar kürgülügen ucir-i sayid tan-a medegülkü bičig-ün eke) (МУТА:М31-2-3862-19):

“öber öberün nutuγ-un jiruγ-i qayučin-i mörden jiruju medegülün küргеjü iregülür-e qariyatu ayimaγ-un olan qosiyun-dur yabuγulun tusiyaysan. edüge qariyatu qosiyud-ača öber öberün nutuγ-un jiruγ-i qayučin-i mörden ayula aliba jüil-i emün-e-eče qoyitu jüg qangdayulun, qoyar imaqu-du tabin yaγar-i bayтаγан jiruju, basakü ali oboγ-a-ača ali oboγ-a kürtel-e yambar jüg tokiyaldoysan-i čay uliral-un toγan-u qorin dörben jüg-tür tokirayulun yurban jaγun jiran alda-yi nigen yaγar, yučin jirγuyan alda-yi nigen qubi bodoju, qubi ilü kürkü yaγar-i alda, alda ilü kürkü yaγar-i či toqoi-bar kemjüy-e bolγan, ali oboγan-ača ali oboγ-a kürtel-e kedüi kemjüy-e-tei, mön ali oboγan-ača ali oboγ-a kürtel-e ali čiyulγan qosiyu qarayul-luγ-a neyilegsen, jегün barayun emün-e qoyitu eteged ereslen kedün yaγar bolqu jerge-yi todorqayilaysan čEsE daγayulun medegülün küргеjü iregsen-i ...” гэж байна.

“Хуучныг мөрдөн” гэж байгаа нь 1889 оны газрын зураг бүтээх зааврыг дага гэсэн үг бөгөөд түүний дараах хэсэг нь тухайн заавраас ишлэсэн хэсэг юм. Түүнчлэн, 1911 онд Чин улс мөхөж, Монгол улс тусгаар тогтнолоо зарласнаас хойш жилийн дараа буюу 1913 онд Богд хаант засгийн газраас гаргасан “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-г ч тэр хэвээрээ орсон байдаг.

<sup>5</sup> Үүний тухай Улиастайн хэвэй сайд нар Хүрээний сайдад явуулсан Бадаргуульт төрийн 16-р оны (1890) бичигт иш татсан байна. (Зураг 6)



## 6. Шинэ бодлого—Хөгжлийн мэдээлэл болсон газрын зураг

Ийнхүү бүтээгдэж ирсэн газрын зураг нь цаг үеийн шаардлагатай нь холбон, монголын газар нутагт хандсан Чин улсын засгийн газрын үзэл хандлагыг үндсээр нь өөрчилжээ.

Монголын хуучны газрын зургуудын дотор, өдгөө хамгийн ихээр үлдсэн нь Бадаргуулт төрийн 33-р он (1907)-д бүтээгдсэн зураг бөгөөд Зураг 2 нь тэдгээрийн нэг болно. Түүний өмнөх жил болох 32-р он (1906)-д “Шинэ бодлого”-ын хүрээнд монголыг засах “Гадаад монголын төрийг засах явдлын яам” (理藩院) нь “理藩部” болгон өөрчилжээ.

Бадаргуулт төрийн 20-иод оны сүүл хагаст Чин улс тухайн үеийг хүртэл баримталж ирсэн хятад болон монгол иргэдийг зааглах бодлогоо өөрчилсөний улмаас, өвөр монголд олон тооны хятад иргэд шилжин суурьших болжээ. Эрт үеийн Чин улсын эрх баригч манж хүмүүсийн хувьд монголчууд нь хэт олон тоотой хятад иргэдийг эсэргүүцэх цэргийн хамтрагч нь байжээ. Тиймээс монгол руу хятад иргэдийг оруулахгүй байх нь тэдний бэлчээрийг хадгалахын зэрэгцээ, хятад монгол иргэд ойртохоос сэргийлж, хятад үсэг бичиг хэрэглэхийг хориглох, монгол хятад иргэдийн гэрлэлтийг хориглох, хятад иргэдийн монгол дахь наймааг хязгаарлах гэсэн бодлогыг баримталж ирсэн билээ. Гэвч хар тамхины дайн (1840-42)-ы дараа нөхцөл байдал ихээр өөрчлөгдөж, Япон-Манжийн дайн (1894-1895)-ы төлбөр төлөх гэх мэт зүйлээс болоод санхүү алдагдалд орж, хятад иргэдийн дургүйцэл ихсэхийн хирээр хятад түшмэд тэргүүлэн “Манж хятад нэгэн гэр бүл” хэмээх уриаг бий болгон, манж хятад хүмүүс нэгдэх болжээ. Нөгөө талд монголын морьтон цэргийн хэрэгцээ шаардлага багасч, хятадыг эсэргүүцсэн манжийн хамтрагч гэсэн байр сууринд ч өөрчлөлт гарлаа. Иймээс Чин улс өнөөг хүртэлх баримталж байсан бодлогоо 180 хэм өөрчилж, монголд хятад иргэдийг суурьшуулах замаар Оросын урагш чиглэсэн бодлогод эсэргүүцлээ илэрхийлж, монголыг захирсан эрх мэдлээ хамгаалах гэх болов.

Бадаргуулт төрийн 32-р он (1906)-ы 11-р сард Гадаад монголын төрийг засах явдлын яам нь дотроо судалгааны алба (調查局) болон эмхэтгэн хэвлэх албыг (編纂局) бий болгож, монголын бүх хошууны мэдээллийг “атар эзэмших, ойжуулалт, бэлчээр, зэрлэг амьтад, амьтны гаралтай түүхий эд, төмөр зам, уурхай, загас агнуур, давс олборлолт, цэргийн тогтолцоо, сургууль, хоршоо, хил хязгаар, худалдаа гэх мэт 14 зүйл зорилтыг тогтоон” (Яно 1916:308), газар бүрийн жанжин сайдаар дамжуулан, газар бүрийн чуулган даргаар хянуулан судалжээ. Дээр дурдсан Сэцэн хан аймгийн чуулган даргаас Хүрээнд суух амбан сайдад барьсан Бадаргуулт төрийн 33-р он (1907) 5-р сарын 29-ний өдрийн өргөх бичигт (МУТА:МЗ1-2-3862-19) буй “Гадаад монголын төрийг засах явдлын яам” (理藩部)-нд айлтгаж, 2-р сард нь бүх аймгуудад мэдэгдсэн “olan bayidal dürsü-yi todorqayilan yagyaqu jüil anggi-yin kegeg” нь энэ судалгааг хэлж байна гэж ойлгогдохоор байна. Үүний хүрээнд 1907 онд хошуудын газрын зураг нэг зэрэг олноороо бүтээгджээ.

Энэхүү судалгааны дүнг хүлээн, Хэвт ёсны 2-р он (1910)-д “Гадаад монголын төрийг засах явдлын яам” нь өмнөх оны шийдвэрийн дагуу Үндсэн хуульт тогтолцоонд бэлтгэх газрыг (憲政籌備處) бий болгож, судалгаа явуулсан хоёр албыг нэгтгэхийн сацуу, Хошуу тогтолцоог судлах газар (藩政研究所) байгуулж, эрхлэх түшмэлийг томилон, яамны (理藩部) зөвлөхтэй хамт хошуу тогтолцоог судлах ажилд оржээ” (Яно 1916:311). Энэ нь өнөөг хүртэлх аймаг хошууны тогтолцоог халж, үндсэн хууль тогтоох гэсэн нэрээр хятад түшмэдээр монголыг шууд захируулах гэсэн тогтолцоонд шилжихийн төлөөх бодлоготой судалгаа байжээ. Тэр ондоо хятад монгол иргэдийг зааглаж байсан хууль ч хүчингүй болов. Ийнхүү өнөөгийн монголын нутагт хятадуудын шууд захирах бодлого эхлэлээ хүлээж байсан бөгөөд уг бодлого чиглэл нь монголын баялгаар монголыг захирах гэсэн зүйл байлаа. Тиймээс өмнөх эрх мэдлээ алдахад хүрсэн хошууны засаг нар төдийгүй, алба гувчуур нэмэгдэж амьдрах эх үүсвэрээ алдах аюулд хүрсэн жирийн монгол хүмүүсийн бухимдал туйлдаа хүрч, гадаад монгол дахь шинэ бодлого зогсон, 1911 оны Чин улсын мөхөл, Монгол улсын тусгаар тогтнолтой золгосон билээ.

Ийнхүү 1910 он нь Чин улсын хувьд гадаад монголын хөгжлийн он гэж үзэж болох бөгөөд түүнийг нь даган дахин газрын зураг бүтээх ажил өрнөжээ. Тухайн үед бүтээгдсэн газрын зураг (Зураг 4)-ийг 1907 оны мөн адил хошууны газрын зураг (Зураг 2)-тай харьцуулан үзвэл өөрчлөгдсөн зүйл бараг алга. Гэхдээ анхаарал татахуйц ялгаатай зүйл нэг л байна. Тэр нь гарчгийн үсгийн баруун дор нэмэлт шошго хадсан явдал бөгөөд түүн дээр хошуунаас нийслэл хүртэлх зай болон хошууны баялагийн талаар дараах зүйл тэмдэглэгджээ.

“ᠵasaγ terigün jerge tayiji Lubsangcöyidubagvangpeleᠵeyidasicerin man-u saγuγ-a ʻaǰar-ača, neyislel qota kürtel-e qoyar mingγan ʻaǰar, man-u nutuγ-tu alingčü jüil-ün modo, görögesö, aγurqai, jiyasu, dabusu-tu naγur ügei.”

Энэ тэмдэглэл нь 1907 оны судалгаагаар газрын зурагтай хамт өргөн барьсан мэдээлэлтэй ижил зүйл юм уу, түүнийг нэгтгэсэн зүйл болов уу гэж таамаглаж байна. Түүнийг газрын зурган дээр хадуулсан нь орон зайн хуваарилалтаар газрын баялгийг захирах арга болгон газрын зургийг ашиглаж байсныг илтгэхийн хамт, Чин улсын монголыг шинэчлэх гэсэн тодорхой зорилгыг харуулж байна. Мөн хошууны зүгээс шошгонд бичсэн агуулга нь баялгийн талаар ихэнхдээ үгүйсгэсэн байгаа бөгөөд энэ нь Чин улсад хандах эсэргүүцэл нь гэж ойлгогдож байна.

Ингээд Чин улсын монголын газрын зургийг бүтээх арга замын талаар нэгтгэн үзвэл, юун түрүүнд Сайшаалт ерөөлтийн үед, Хураангуй хууль бичгийн эмхэтгэл гэсэн Чин улсын газар нутгийг захирах тогтолцоонд монголыг оруулах ажлын хүрээнд монголын хошуудын газрын зураг хийгджээ. Улмаар, Бүрэнт засагчийн үед Чин улс монголыг захирах эрхээ Орост алдахгүйн тулд газрын зураг бүтээхэд хэмжилт болон хятадын уламжлалт график шугам (計里画方)-ыг нэвтрүүлжээ. Тийнхүү бүтээгдсэн зураг нь баялгийн орон зайн хуваарилалтыг хянах боломжтой болгож, Чин улсын сүүлчийн жилүүдэд монголын хөгжлийн бодлогын үндсийг бий болгожээ.

### **Төгсгөлд нь — Нүүдэллэх газраас хөгжлийн талбар болох орон зай руу-**

Бадаргуулт төрийн сүүлчийн жилүүд хүртэл Чин улс монголыг нүүдэллэн аж төрөх газар гэж ойлгож байлаа. Орчин цагийн монгол хэлээр “газрын зураг” гэдэг боловч, хошууны газрын зургийн гарчиг нь “хошууны газрын зураг” бус, “хошууны нутгийн зураг” (qosiγun-u nutuγ-un jiyuγ) гэж байдаг. Хятадаар “нутгийн зураг” нь Зураг 2 дээрх газрын зургийн зүүн талд харагдаж байгаачлан “游牧圖” (нүүдлийн зураг) гэж орчуулагдахаар байна. “хошууны нутгийн зураг” нь “хошууны нүүдлийн зураг” бөгөөд “хошууны нутаг дэвсгэрийн зураг” байсангүй. Жан зохиогчийн монголын газар зүйн бичиг ч мөн “蒙古游牧記” (1859 оны хэвлэл) “Монголын нүүдлийн тэмдэглэл” гэсэн нэртэй байжээ. Энд гарч буй “нутаг”-ийг Монгол хэлний товч тайлбар толь (Цэвэл 1966)-д “оршин суух газар орон” гэж тайлбарлажээ. Монголд оршин суух гэдэг нь нүүдэллэн мал аж ахуй эрхлэх гэсэн үг бөгөөд газар гэдэг нь бэлчээрийг заадаг байжээ. Чин улсын засгийн газар үүнийг монголчуудтай адил ойлгож байсан нь Чин улсын хаадууд нь хятад доторхи эзэнт улсын хуанди төдийгүй, адилхан нүүдэлчин угсааны Чингис хаанаас улбаатай “хаан” гэсэн ойлголт байсан учраас тэр юм. Монголын газар нутаг нь одоогийнх шиг эрх мэдлийн доорхи орон зай болсон “нутаг дэвсгэр” гэгдэхээсээ өмнө нүүдэлчин ард түмэн нүүдэллэн аж төрж ирсэн “бэлчээр нутаг” байжээ<sup>6</sup>.

Бэлчээр нь нэрэн дээрээ хуандигаас шан болгон авсан гэх боловч, нүүдлийн аж ахуйд нь хуандийн шууд оролцоо байхгүй, бэлчээр ашиглалт нь монгол дотроо зохицуулагдаж

<sup>6</sup> Монгол нутгийн онцлогийн талаар дээр дурдсан Бүрэнт Засагчийн 3-р он (1864 он)-ы 2-р сарын 21-ний Түшээт хан аймгийн “Хамаарсан да хэбэй түшээ гүнгийн бичиг” (МУТА:М9-3-4883-2)-т “mongγol ʻaǰar örgön aγudam metü, kümün cöken bölbači, yerü dotoγadu ʻaǰar-un adali nigen ʻaǰar-tur bayingγu saγuqu ba, tariyanlang, mal-un teǰigel quriyaqu ebesü ügei, biden-ü mongγolčud cöm dörben jüil-ün mal-dur itegejü, alban-i jalγamjilan aju töröküi-dür ʻyobi tal-a ʻaǰar-tur usu qobor ündüsü seyireg, imayta mal-un belčiger ebesü usu erejü negüüdel-iyer ke-süjü nutuγlaqu anu, uγ-ača dotoγadu ʻaǰar-un adali narin kemjijeygen ügei böged, ...” (дээрх ишлэлийн үргэлжлэл) гэж дурдсан билээ.


байв. Хошуу захирах засгийн байр суурь ч “Гадаад монголын төрийг засах явдлын яам”-аар дамжин хуандийн томилдог түшмэл байхын зэрэгцээ, засаглах, шүүх, алба гувчуур авах, цэрэг татах гэх мэт эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн язгууртан захирагч ноёд байжээ. Энэхүү манжийн дарлалын үеийн бэлгэдэлт ба бодит давхар чанар нь бэлчээр ашиглалт дээр ч адил байсан байх гэж бодож байна. Хошууны хил хязгаар ба тэнд аж төрөх хүмүүс нь угтаа хошууны хилийг даван нүүдэллэх нь хориотой, зөрчвөл хатуу торгох хууль байсан ч уртаас урт тогтсон хилийг нэг бүрчлэн хянах боломж байхгүйн дээр овооны хооронд хилийн шугам татсан нь үгүй. Үнэндээ бэлчээрийн төлөөх өрсөлдөөн л байхгүй бол бэлчээрийн хил хязгаар уян хатан байдлаар ашиглагдсаар ирсэн бизээ. Монгол шиг хувирамтгай цаг агаартай газар хил даван нүүдэллэх нь таамаглахын аргагүй цаг уурын өөрчлөлтийг даван гарах хамгийн үр дүнтэй арга учраас тэр юм. Ган зуд гэсэн байгалийн гамшиг болсон үед аймаг чуулганаас хошууны гадна харьяат малчид болон малыг гаргах нь ховор зүйл байгаагүй. Өнөөгийн монголын малчид ч бэлчээрийн хилийг тодорхой тогтоох нь бэлчээр тойрсон маргааныг дэвэргэнэ үү гэхээс багасгахгүй хэмээн онцолдог. Хил хязгаарыг тодорхой харуулсан газрын зураг нь нэр төдий байсан хуандийн монгол газрыг эзэмших эрхийг бодит болгон, бэлчээрийн өрсөлдөөнд шууд орох арга замыг нээж өгчээ.

Улмаар шинэ аргаар бүтээгдсэн газрын зураг нь Чин улсын эрх баригчдын монголын газар нутагт хандах ойлголтыг эрс өөрчилжээ. Масштабгүй хуучин газрын зураг нь засаг ноёдын захирах хошууг “хэлбэр”-гүй нэгж байдлаар дүрсэлж, тухайн хошуу бусад хошуудтай хэрхэн хиллэдэгийг зааж байв. Тэрхүү орон зай нь байршил зүйн “тэгш гөлгөр орон зай” (smooth space) (Deleuze & Guattari 1994) юм. Үүний эсрэг масштаб бүхий шинэ газрын зураг нь дээрх судлаачдын яг хэлсэнчлэн “судалтай орон зай” (striated space) болох юм. Улмаар “газрын зурган лого” нь дэлхийн газрын зургаас “хэлбэр”-ээ аван сугарч гарсаны эсрэг, шинэ хошууны газрын зураг нь эвлүүлдэг зурагны нэгэн хэсэг шиг аймгийн газрын зураг болон Чин улсын газар нутгийн зурганд шигтгээ болон орж байгаа юм. Тэрхүү хоромд, хошууны “хэлбэр” нь дахин уусаж, монгол хэмээх газар нь хятад газраас үргэлжлэх масштабт зургийн нүдэнд багтаж, түүнтэй нь зэрэгцэн газар болон нүүдэлчин ахуйн уялдаа, хошууны хагас засаглах эрх ч задарсан. Хуанди бэлчээрт баригдалгүй, газартай холбоотой бүхий л эрхийг хэрэгжүүлж чадахаар болж, шинэ хошууны зураг нь, тухайн шугаман нүдэн дотор баялаг хир багтсан бол гэдгээр хэмжигдэх “судалтай орон зай” руу газрын талаарх ойлголтыг эргүүлсэн юм. Ийнхүү монгол хэмээх газар монголчуудын нүүдэллэн амьдарч ирсэн “бэлчээр нутаг” байхаа больж, хятад иргэд тариа тариалж, уул уурхайг нь ухаж малтах гэсэн хөгжлийн талбар орон зай болсон юм.






**Зураг 4** /зүүн/ Сэцэн хан аймгийн тэргүүн зэрэг тайж хоёр зэрэг тэмдэглэсэн Лувсанчойдов-Агваанпэлжээ-Дашцэрэнгийн хошууны нутгийн зураг /Халхын зүүн замын дундад адгийн баруун хошуу/ (1910), ХБНГУ-ын Берлиний мужийн номын сан.  
([http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-IIIH\\_Hs\\_or\\_0138](http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-IIIH_Hs_or_0138))  
/баруун/ Улаан хүрээн дотор харуулсан газрын баялгийн талаарх тэмдэглэлийг томруулсан байдал.




**Зураг 5-1** Түшээт хан аймгийн Жан чин мэнд явах хоёр зэрэг нэмсэн зургаан зэрэг тэмдэглэсэн гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж Чимэддоржийн хошууны нутгийн зураг (Бүрэнт засагчийн 7-р он (1868)) Тамгын бичиг: Qalq-a-yin qoyitu jam dumdadu jegün eteged-ün qoşiyu -yi jakiryüci-yin tamaγ-a. (МУТА:М9-3-5286-15)






Зураг 5-2 Хамт өргөгдсөн ‘Өргөх цэс’ (МУТА:М9-3-5289-17)




Зураг 5-3 Мөн ‘Хүсэн батлах бичиг’ (МУТА:М9-3-5289-18)





Зураг 6 Улиастайн хувийн сайд нар Хүрээний сайдад явуулсан бичиг. Бадаргуулт төрийн 16-р он (1890). (МУТА: М1-1-6494-7)



Зураг 7 Зарлигаар тогтоосон мужийн зураг, хэмжээний дүрэм (欽定畫圖格式) 1890 он. (МУТА: М31-2-3862-22)

## НОМЗҮЙ

- Anderson (Андерсон, Бенедикт) 2007 『定本想像の共同体—ナショナリズムの起源と流行』白石隆・白石さや訳, 書籍工房早山. (Anderson, B.1991, *Imagined Communities: Reflections on the Origin and Spread of Nationalism*. Revised Edition. London and New York: Verso.)
- Baddeley, John, F. 1919. *Russia, Mongolia, China*. Vol.1. London: Macmillan and Company.
- Foucault (フーコー, ミシェル)1977 『監獄の誕生—監視と処罰』田村淑訳, 新曜社. (Foucault, Michel, 1975. *Surveiller et punir, naissance de la prison*. Paris, Gallimard.)
- Deleuze & Guattari (ドゥルーズ, ジル&ガタリ, フェリックス) 1994 『千のプラトー—資本主義と分裂症』宇野邦一・田中敏彦・小沢秋広訳, 河出書房新社. (Deleuze, Gilles& Guattari, Félix, 1980. *Mille Plateaux : Capitalisme et schizophrénie*. Éditions de Minuit.)
- Futaki, H. 2005. A Description of Boundary Reports (nutuγ-un cese) written in Outer Mongolia in the 1920s. In: Futaki and Kamimura 2005, pp. 27-59.
- Futaki, H. and Kamimura, A. (eds.) 2005. *Landscapes Reflected in Old Mongolian Maps*. 2005. Tokyo.
- Гончигдорж, Б. 1970. Монголчуудын газар зүйн зургийн түүхийн зарим асуудал. *Шинжлэх Ухааны Академийн Мэдээ*, 1970-1: 54-66. УБ.
- Kamimura, Akira (上村明) 2010 「国土・国境・国民：戦争の想像力—『祖国』防衛戦争としてのハルハ河戦争—」今西淳子・フスレ編『ノモンハン事件(ハルハ河会戦)70周年 2009年ウランバートル国際シンポジウム報告論文集』519-530ページ, 風響社.
- Kamimura, A. 2005. A Preliminary Analysis of Old Mongolian Manuscript Maps: Towards an Understanding of the Mongols' Perception of the Landscape. In: Futaki and Kamimura 2005, pp. 1-26.
- Oka, Hiroki (岡洋樹) 1988 「ハルハ・モンゴルにおける清朝の盟旗制支配の成立過程—牧地の問題を中心として—」『史学雑誌』97-2: 1(145)-32(176).
- Perdue, Peter C. 1998. Boundaries, Maps, and Movement: Chinese, Russian, and Mongolian Empires in Early Modern Central Eurasia. *The International History Review* 20 (June 1998): 263-286.
- Шагдарсүрэн, Ц. 2003. Монголчуудын уламжлалт газрын зураг. In: Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын утга соёлын товчоон*, pp.15-28. УБ.
- Цэвэл, Я. 1966. *Монгол хэлний товч тайлбар толь*. УБ.
- Tuan (トゥアン, イーファー) 1993 『空間の経験—身体から都市へ』(ちくま学芸文庫)山本浩訳筑摩書房. (Tuan, Yi-Fu, 1977. *Space and Place: The Perspective of Experience*. Minneapolis, MN: University of Minnesota Press.
- Unno, Kazutaka (海野一隆) 2004 『東洋地理学史研究—大陸篇』清文堂.
- Wakabayashi, Mikio (若林幹夫) 2009 『地図の想像力』(河出文庫)河出書房.
- Winichakul (ウィニッチャクン, トンチャイ), 2003 『地図がつくったタイ—国民国家誕生の歴史』(明石ライブラリー)石井米雄訳, 明石書店. (Winichakul, Thongchai. 1994. *Siam Mapped: A History of the Geo-Body of a Nation*. University of Hawaii Press.)
- Yano, Jin'ichi (矢野仁一) 1916 『近代蒙古史研究』弘文堂書房.
- Yan, Ping et al. (eds.) (阎平, 孙果清等编著) 1995 『中华古地图集珍』西安地图出版社.
- Zhang, Mu (張穆撰) 1859 『蒙古遊牧記』(1859年刊行).

(Япон хэлнээс орчуулсан: Ц. Онон, А.Камимүра)